

“Булл капитал ББСБ” ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

“Булл Капитал ББСБ” ХХК-ийн 2024 оны Үйл ажиллагааны нэгдсэн тайланг хүргэж байна. Компанийн хувьд тухайн жилд Бизнес төлөвлөгөөний дагуу тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн ханган ажилласныг мэдээллэхэд таатай байна.

Бид 2024 онд уламжлалт зээл буюу Бизнесийн зээл, бизнесийн зээлийн шугам, автомашины зээл, шуурхай зээлийн бүтээгдэхүүн болон Итгэлцэлийн үйлчилгээг салбар нэгжүүдээрээ дамжуулан харилцагчдад санал болгож ажиллалаа.

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	Компанийн 2023 оны Санхүүгийн үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, хэлэлцсэнээр нийт ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн.
2	Компанийн ТУЗ-өөр эцэслэн батлагдсан 2024 оны Төсвийн төлөвлөгөөний дагуу бүх нэгжүүдэд төлөвлөгөөг хуваарилж, гүйцэтгэлийг дүгнэсэн.
3	Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Өлзийт аккаунт аудит” ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэж, баталгаажуулан Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны вэб сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн.
4	Санхүүгийн зохицуулах хорооноос сар бүр, улирал бүр компанийн шаардлагатай тайлан мэдээг гаргуулж, үйл ажиллагаанд зайнаас хяналт, шалгалт хийдэг ба 6-р сард компанид газар дээрх хяналт, шалтгалтыг хийж, “Үйл ажиллагаа хэвийн, сайн” үнэлгээг өгсөн.
5	Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, эх үүсвэрийн зардлыг бууруулах, эх үүсвэрийн бүтцийг төрөлжүүлэх зорилгоор 9-р сард Олон улсын хөрөнгө оруулалтын сангаас тодорхой хэмжээний санхүүжилтийг амжилттай татсан.
6	Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой, эрсдэлгүй үйл ажиллагааг олон улсын стандарт, арга барилаар явуулах зорилгоор 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Олон улсын хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэх ажлыг 4-р улиралд эхлүүлээд байна.
7	Эрсдэл, аюулгүй байдлын шаардлага бүрэн хангасан үндсэн бүртгэл болон дотоод бүртгэлийн системүүдийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлсэн.
8	ҮЦАЭХ-ны зөвшөөрлийн дагуу Биржийн бус зах дээр 3-р сард 5.8 тэрбум төгрөгийн дүн бүхий “Булл бонд 4”, 9-р сард 6.1 тэрбум төгрөгийн дүн бүхий “Булл бонд 5”-ыг тус бүр хаалттай хүрээнд “Мандал капитал маркетс”ҮЦК-тай хамтран амжилттай гаргасан.
9	Биржийн бус зах дээр 2023 онд гаргасан “Булл бонд 2” болон “Булл бонд 3”-ийг тус бүр хуваарийн дагуу бүрэн төлж хааснаар хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ зохих



	ёсоор биелүүлсэн. Мөн Санхүүгийн байгууллагууд болон “Булл бонд 4” болон “Булл бонд 5”-ийн хөрөнгө оруулагчид, Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэн ажиллаж байна.
10	Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 4-р сард ХУД, Horse motors Автомашины худалдааны төвд “Яармаг” салбар, 10-р сард Баянзүрх дүүрэгт “Сансар” салбарыг тус тус шинээр байгуулсан.
11	Компанийн үйл ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж байгаатай уялдан Санхүүгийн зохицуулах хорооноос “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” тусгай зөвшөөрлийг нэмж авсан.
12	Ажилтнуудын ажиллах таатай орчныг бүрдүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай чиг үүргүүдийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Нарны зам гудамж 21/3, Жигүүр гранд оффисийн 3-р давхарыг худалдан авч, тус байршилд төв оффис, төв салбарын үйл ажиллагааг явуулж эхлүүлээд байна.
13	Компанийн хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 28 ажилтан шинээр нэмж, 8 ажилтан албан тушаал дэвшиж, 15 ажилтан ажлаас чөлөөлөгдсөнөөр үндсэн ажилтны тоо 43 болсон.
14	Үйл ажиллагаанд шаардлагатай 3 журмыг шинээр боловсруулж, 2 журамд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан ба Хүний нөөцийн хэлтсээс нийт ажилтнуудын дунд заавар, журам таниулах сургалтыг тухай бүр зохион байгуулсан.
15	ТУЗ нь 2024 онд нийт 49 удаа хуралдаж, 49 асуудлыг хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн 60-100% ирцгэйгээр хэлэлцэн шийдвэрлэсэн ба нийт 49 тогтоол баталсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none">✓ Хаалттай хүрээнд Үнэт цаас гаргахтай холбоотой 2 тогтоол,✓ Аудитын байгууллагыг сонгон ажиллуулахтай холбоотой 2 тогтоол,✓ Компанийн бүтэц, зохион байгуулалт, Төсвийн төлөвлөгөөтэй холбоотой 2 тогтоол,✓ Салбар байгуулахтай холбоотой 2 тогтоол,✓ Компанийн үндсэн үйл ажиллагааг эсрдэлгүй, тогтвортой, тасралтгүй явуулах хүрээнд 32 тогтоол,✓ Сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэлтэй холбоотой 9 тогтоол.
16	Нийт ажилтнууддаа зориулж гадаад, дотоодын чиглүүлэх, мэргэшүүлэх, идэвхжүүлэх чиглэлийн 11 удаагийн 22 цагийн сургалт, удирдах ажилтнуудад зориулсан 48 сургалт, салбар болон газар, хэлтсийн захирлуудаа 104 цагийн 12 удаагийн сургалтад тус тус хамруулсан.
Эрсдэлийн удирдлага:	
17	✓ Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, Төрийн зохицуулагч байгууллагуудын




шийдвэр, чиглэлийг анхааралтай ажиглаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажилласан.

- ✓ Бүтээгдэхүүн, Санхүү, Комплаенс, Үйл ажиллагааны эрсдэл тэдгээртэй холбоотой процессыг дахин үнэлж, нэгжүүд хоорондын уялдаа холбоог сайжруулсан.
- ✓ **ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь** эрсдэлийн төрөл, хэмжээ, хязгаарыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн нийт 23 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд:
 - Комплаенсийн эрсдэлийн үнэлгээнд дүгнэлт гаргаж, Эрсдэлийн тайланг хэлэлцэн, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.
 - Их хэмжээний хэлцэл хийхтэй холбогдуулан эрсдэлд дүгнэлт гаргаж, нийт 21 шийдвэрийг хэлэлцэн баталсан.
- ✓ Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд улирал бүр Санхүү, хууль, эрсдэл, комплаенс, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгжүүдээс холбогдох тайлан, мэдээнүүдийг авч хэлэлцэн, зохих үүрэг чиглэлийг өгч, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Гүйцэтгэх удирдлага, эрсдэл хариуцсан нэгжид зохих зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан.
- ✓ **ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь** тайлант хугацаанд нийт 3 удаа, 80-100 хувийн ирцтэйгээр хуралдсан. Хороо нь Дотоод аудитын хэлтсийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шууд удирдлагаар хангаж ажилласан. Дотоод аудитын хэлтэс нь төлөвлөгөөний дагуу бүх салбарт төлөвлөгөөт аудитын хяналт хийж, зохих зөвлөмжүүдийг өгч ажилласан. 2024 онд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийх хэлцлийн талаар, Олон улсын Аудитын байгууллагыг сонгон ажиллуулах талаар, санал, дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн. Мөн Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлуулсан байна. “Аудитын хорооны үйл ажиллагааны журам”, “Дотоод аудитын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн батлуулсан.
- ✓ Санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор давхар болон дараалсан хяналтын систем нэвтрүүлж, мөнгөн урсгал төлөвлөлтийг тогтмол хийн хөрвөх чадварыг ханган ажилласан.
- ✓ Санхүүгийн зохицуулах хорооноос мөрдүүлдэг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”-ны тоон болон чанарын шаардлагыг хангахад чиглэсэн сургалт, судалгааг хийж ажилласан.
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын хэвийн үйл ажиллагааг хангах, нууцлалыг хамгаалах, мэдээллийн системийн хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор тогтмол хяналт



	тавьж, сайжруулалт хийн ажилласан байна.
	Байгаль орчин, нийгэм эдийн засгийн эрсдэлийн удирдлага:
18	<ul style="list-style-type: none">✓ Эрсдэл хариуцсан нэгжээс “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороогоор Эрсдэлийн тайланг хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан.✓ “Зээлийн бодлого”-д Байгаль орчин, нийгэм эдийн засагт ээлтэй байх стандартыг баримталж ажиллах, Монгол улсын хууль тогтоомжид хориглосон үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлсээр ирсэн нь бид үйл ажиллагаагаараа дамжуулан байгаль орчин, хүн ам, тэдгээрт хор хөнөөл учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорьж байна.✓ ТоС холбооны гишүүн байгууллагын хувьд ТоС Холбооноос өгөх чиглэл, сургалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэлэлцүүлэгт идэвхитэй оролцож, байгаль орчинд ээлтэй байх зарчмын хүрээнд ажиллалаа.
	Сургалт, хөгжүүлэлт чиглэлээр:
19	Ажилтнуудын зөв зохион байгуулалт, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад тус нэмэр болох зорилгоор салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн Аюурвэд төвийн багш Болороо “Шим тэжээлийн үндэс”, Полиси төвийн багш Эрдэнэгэрэл “Ажилдаа дурлах нь”, мөн багш Чинзориг “Амжилт бол сонголт” сэдвүүдээр 3 удаагийн 8 цагийн сургалт, өдөрлөг сургалт зохион байгуулсан.
20	Ажилтнуудыг ажил мэргэжлийн хүрээнд чадавхижуулах зорилгоор шаардлагатай чиглэл бүрээр байгууллагын дотоод сургалтанд 20 удаа, гадаад сургалтанд 23 удаа тус тус хамруулсан. Тодруулбал Монгол банк, СЗХорооноос зохион байгуулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд” хэлэлцүүлэг, Тос холбооны “ТХЗ-уудын санхүүжилтийн таксономи” сургалт, МББСБХолбоо болон "Сэтгэх урлаг" байгууллагаас хамтран зохион байгуулсан “Гүйцэтгэх удирдлагын манлайлал” сургалт, Монголын үндэсний дотоод аудиторуудын холбооноос зохион байгуулсан “Өөрчлөлтийг хүлээн авч, үнэ цэнийг нэмэгдүүлье” форум, “ББСБ-ын нягтлан бодогч нарт зориулсан сургалт”, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн сургалт, Санхүүгийн мэргэшүүлэх академийн сургалт, Хүний нөөцийн удирдлагыг мэргэшүүлэх зэрэг сургалтуудад холбогдох ажилтнуудыг тус тус хамруулсан.
21	Компанийн ажилтнуудад Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон Дотоод хяналтын хөтөлбөрийн талаар цахим болон танхимын сургалт зохион байгуулсан.
22	Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагуудын хамтран зохион байгуулсан банкнаас бусад салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан



	зохион байгуулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ойлголтыг сайжруулах нь” сэдэвт сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулсан.
Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр:	
23	“Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр” болон “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын дагуу хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа харилцан ашигтай байх, тэдгээрт тогтсон цаг хугацаанд буюу санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар хүргэж байна.
24	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, стратеги түүний хэрэгжилтийн мэдээлэл, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдал, Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийн талаарх мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллүүдийг Хөрөнгө оруулагч, бусад оролцогч нарт www.bullcapital.mn цахим хуудас, биечилсэн уулзалт, info@bullcapital.mn цахим шуудан, 77303377 лавлах утасны дугаар, холбоо харилцааны бусад хэрэгслүүдийг ашиглан тогтмол нээлттэй мэдээллэж, санал хүсэлт, гомдлыг мөн нээлттэй хүлээн авч шийдвэрлэх, сайжруулах тасралтгүй систем ажиллаж байна.
25	<ul style="list-style-type: none">✓ ТоС холбооны гишүүн байгууллагын хувьд хагас жил тутам холбогдох тайланг тус холбоонд хүргүүлэхийн зэрэгцээ ББСБ-ын мэргэжлийн зөвлөлд хамтран ажилласан.✓ “Монголын тогтвортой санхүүгийн форум 2024” хүрээнд зохион байгуулсан “Уур амьсгалын тайлагнал, хөрөнгө оруулалтын боломжууд”, “Тогтвортой хөгжилд хөрөнгийн зах зээлийн оролцоо” хэлэлцүүлгүүдээс гадна бусад өндөр түвшний хэлэлцүүлгүүдэд оролцсон.
26	Тэргүүлэгч арилжааны банк, санхүүгийн байгууллагууд, дотоодын зах зээлд тэргүүлэгч даатгалын компаниудтай хамтын ажиллагаа улам өргөжин тэлсэн.
Нийгмийн хариуцлагын хүрээнд:	
27	 Компанийн нийт ажилтнууд болон тэдний гэр бүлийнхний дунд нөхөрсөг спорт өдөрлөг зохион байгуулсан.
28	“NURA Mongolia” болон “Дөрөвдүгээр” эмнэлэгүүдтэй хамтран компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн цогц шинжилгээ, оношлогоо, үзлэгт хамруулсан.

29		<p>Эх үрсийн баярыг тохиолдуулан нийт ажилтнуудынхаа хүүхдүүдтэй “Adventure zone” тоглоомын төвд нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлж, хүүхдүүддээ компанийн зүгээс хүүхдийн баярын бэлэг гардуулсан.</p>
30		<p>Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр зохион байгуулагддаг байгаль орчинд ээлтэй ажлын хүрээнд хамт олноороо Богд уулын Дугуй цагаан хад орчмын хогийг 6-р сард цэвэрлэсэн.</p>
31		<p>Компанийн хамт олны уур амьсгал, соёлыг түгээх зорилготой нийт ажилтнуудыг хамруулсан зуны арга хэмжээг зохион байгуулсан.</p>
32		<p>10-р сард “Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо”-оос зохион байгуулсан 5 төрөлт спорт арга хэмжээнд байгууллагаараа амжилттай оролцсон.</p>

Санхүүгийн үзүүлэлт:

Компанийн 2022, 2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд /сая.төг/	2022	2023	2024	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	СЗХ-нд илгээсэн	2024/2023
Санхүү байдлын тайлан				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,209.36	3,286.55	13,314.29	305%
Нийт зээл	22,223.77	47,597.28	73,381.88	54%
Зээлийн эрсдэлийн сан	-124.27	-722.17	-945.12	31%
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	626.34	1,515.54	1,757.23	16%
Бусад авлага	217.12	0.00	127.90	0%
Бусад хөрөнгө	40.65	296.74	2,449.64	726%
Үндсэн хөрөнгө	173.63	217.02	3,154.00	1353%
Нийт хөрөнгийн дүн	25,366.60	52,190.96	93,239.82	79%
Итгэлцэл, бусад өр төлбөр	16,314.42	33,686.94	64,951.35	93%
Дүрмийн сан	7,400.00	12,199.83	12,199.83	0%
Хуримтлагдсан ашиг	1,652.17	6,304.19	16,088.63	155%
Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн	25,366.60	52,190.96	93,239.82	79%

Орлого, үр дүнгийн тайлан				
Хүүгийн орлого	4,109.23	13,399.17	24,069.99	80%
Хүүгийн зардал	963.16	5,122.17	9,954.96	94%
Цэвэр хүүгийн орлого	3,146.07	8,277.01	14,115.03	71%
Хүүгийн бус орлого	229.49	992.93	1,272.52	28%
Хүүгийн бус зардал	1,390.35	1,381.86	3,023.21	119%
Эрсдэлийн сангийн зардал	124.27	597.89	223.87	-63%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	1,860.94	7,290.19	12,140.47	67%
Ү/А-ны бус орлого	0.00	0.00	13.10	100%
Ү/А-ны бус зардал	47.49	95.83	319.19	233%
Татвар төлөхийн өмнөх ашиг	1,813.46	7,194.36	11,834.38	64%
Орлогын татварын зардал	184.09	890.34	2,049.94	130%
Цэвэр ашиг	1,629.37	6,304.02	9,784.44	55%

2024 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдийг 2023 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт хөрөнгө 41.0 тэрбум төгрөг буюу 79%-иар, нийт зээлийн багц 25.8 тэрбум төгрөг буюу 54%-иар тус тус өссөн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 2.14% байна.

Бид 2024 онд “Булл бонд 4” болон “Булл бонд 5”-ыг Биржийн бус зах дээр гаргаж, 11.9 тэрбум төгрөгийн татан төвлөрүүлсэн, мөн Банк, санхүүгийн байгууллага болон Итгэл хүлээлгэгч нараас шаардлагатай эх үүсвэрүүдийг татсанаар бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 62.2 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны эцсээс 99.0%-иар өссөн байна.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд 2024 оны жилийн эцсийн байдлаар татварын дараах цэвэр ашиг 9.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 55%-иар өссөн ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьдаг зохистой харьцааны бүх шалгууруудыг ханган ажиллалаа.

“БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК

2025.01.13